



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2023 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ 85.4 ХУВЬТАЙ БАЙНА.

АУДИТЫН НЭР: ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2023 ОНЫ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР
ДҮН

АУДИТЫН КОД: АРА-2024/18-01-ШТА-ГА

Архангай аймаг 2024 он



Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Т.Байгалмаа

Утас: 77333141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 77332268 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn

Ахлах аудитор Г.Цог-Эрдэнэ

Утас: 99210906 Цахим хаяг: Tsogerdeneg@audit.gov.mn

Аудитор Н.Энхчимэг

Утас: 89891150 Цахим хаяг: Enkhchimegn@audit.gov.mn

Аудитор Б.Азантунгалаг

Утас: 94658633 Цахим хаяг: Azantungalagb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах
хаягаар авна уу.



АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	4
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ.....	4
АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ.....	5
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	6
АУДИТЫН ДҮН.....	7
БҮЛЭГ А. 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР БАТАЛСАН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗУРАГ ТӨСӨВ, АЖЛЫН ДААЛГАВРЫГ ТӨСӨВ БАТАЛСНААС ХОЙШ БОЛОВСРУУЛСАН НЬ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬТАЙ НИЙЦЭХГҮЙ БАЙНА.....	9
<i>А.1. Аймаг, сумын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан төсөл арга хэмжээ нь төлөвлөлтийн шаардлага хангаагүй байна.....</i>	<i>9</i>
<i>А.2. 2023 онд аймаг, сумдын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний 15.5% нь урсгал шинжтэй арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.....</i>	<i>10</i>
<i>А.3. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн арга хэмжээний 60 хувь буюу 36 төсөл арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэж олгоогүй байна.....</i>	<i>11</i>
БҮЛЭГ Б. АЙМАГ, СУМДЫН ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ 87.5 ХУВИЙГ ГЭРЭЭНИЙ ХУГАЦААНД ГҮЙЦЭТГҮҮЛЖ АШИГЛАЛТАД ХҮЛЭЭН АВСАН БАЙНА.....	12
<i>Б.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон авто замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн нийт ТАХ-ний хэмжээний 87.5 хувь нь гэрээний хугацаанд хэрэгжжээ.....</i>	<i>12</i>
<i>Б.2. Аймгийн авто замын сан, сумын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.....</i>	<i>14</i>
<i>Б.3. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн нийт ТАХ-нээс 446.5 сая төгрөгийн 9 төсөл арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.....</i>	<i>14</i>
<i>Б.4. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан байна.....</i>	<i>15</i>
БҮЛЭГ В. ХЭРЭГЖСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ 85.4 ХУВЬ НЬ ТӨЛӨВЛӨСӨН ҮР ДҮНД ХҮРСЭН БАЙНА.....	15
<i>Тайлант онд хэрэгжсэн нийт 60 ТАХ-г зориулалтын дагуу, бүрэн хүчин чадлаар ашиглаж байна.....</i>	<i>15</i>
<i>В.2. Аймаг сумдын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан ТАХ-ний 85.4 хувь нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн байна.....</i>	<i>16</i>
<i>В.3. Өмнөх аудитаар өгсөн 2 заалт бүхий зөвлөмж, 6 албан шаардлагын хэрэгжилт дунджаар 75 хувьтай байна.....</i>	<i>16</i>
ДҮГНЭЛТ.....	10
ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ.....	22



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛ

Товчлол	Тайлал
МУЗГ	Монгол Улсын засгийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗД	Засаг дарга
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНТХО	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Дугаар	Нэр
Хүснэгт 1	ОНТХО-ын батлагдсан төсөл арга хэмжээний өөрчлөлт
Хүснэгт 2	Орон нутгийн замын сангийн батлагдсан төсөл арга хэмжээний өөрчлөлт
Хүснэгт 3	Төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээ
Хүснэгт 4	Төсөл арга хэмжээний санхүүжилтийн судалгаа
Хүснэгт 5	Батлагдсан төсөл арга хэмжээний өөрчлөлтийг харуулбал
Хүснэгт 6	Он дамжин хэрэгжсэн төсөл арга хэмжээ
Хүснэгт 7	Нягтлан бодох бүртгэлд тусгаагүй төсөл арга хэмжээ
Хүснэгт 8	Ашиглалтад хүлээн авсан төсөл, арга хэмжээний судалгаа



АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

АУДИТЫН НЭР:	“Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”
АУДИТЫН КОД:	АРА-2024/18-01-ШТА-ГА
АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ:	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны “Аудитын сэдэв батлах тухай” 08 дугаар тогтоол, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан аудитын төлөвлөгөөг үндэслэн хийлээ.
АУДИТЫН ЗОРИЛТ:	<p>Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтаар Архангай аймагт хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг Үндэсний аудитын газар, аймгийн ИТХ, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.</p> <p>Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ▪ Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний холбогдох тооцоолол, баримт бичгийг үндэслэлтэй боловсруулж, санхүүжүүлсэн эсэх; ▪ Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж хүлээн авсан эсэх; ▪ Хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх;
АУДИТЫН ХАМРАХ ХҮРЭЭ:	Архангай аймгийн 2023 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, автозамын сангийн хөрөнгө оруулалт, Эрдэнэбулган, Хашаат, Жаргалант сумын ИТХ-аар баталсан сумын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлсэн аймгийн ЗДТГ, СТСХ, ХОХБТХ, ГХБХБГ, ОНӨГ, Эрдэнэбулган, Жаргалант, Хашаат сумын ЗДТГ болон холбогдох бусад байгууллага, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан төсөл арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ түүний хэрэгжилт, баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, олгосон санхүүжилт, эрх бүхий байгууллагуудаас хяналт хийсэн ажлын тайланг хамруулан төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн хүрээнд аудитыг хийлээ.
АУДИТЫН АРГА ЗҮЙ:	Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS6817-7:2020 Гүйцэтгэлийн



аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгаа явуулах зэрэг Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөөний арга зүйг ашиглан гүйцэтгэлээ.

АУДИТАД АШИГЛАСАН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:

- ✓ Төсвийн тухай хууль,
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль,
- ✓ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль,
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- ✓ Барилгын тухай хууль,
- ✓ Авто замын тухай хууль,
- ✓ Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр

Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам

- ✓ Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”,
- ✓ Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”,
- ✓ Сангийн сайдын 2021 оны 124 дүгээр тушаалаар баталсан “Харьцуулалтын аргаар бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг”,
- ✓ Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам, болон холбогдох аргачлалууд”,
- ✓ Барилга байгууламж үнэ бүрдэл, төсөв зохиох норм ба дүрэм, стандарт,
- ✓ Архангай аймгийн ИТХ-ын тогтоолууд
- ✓ Архангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл,
- ✓ Архангай аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр,
- ✓ Архангай аймгийн хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөө,
- ✓ Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжүүд,
- ✓ Батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, ажил гүйцэтгэх гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд.

АУДИТ ХИЙСЭН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА:

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа хянан удирдаж, аудитын менежер Д.Нэргүйбаатар аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Цог-Эрдэнэ, аудитор Н.Энхчимэг, Б.Азантаунгалаг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2024.02.26-2024.04.19-ны хооронд хийж гүйцэтгэлээ.

АУДИТЫН ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ, ТҮҮНД

Аудитын тайлан нь аудитын зорилт, дүн, дүгнэлт, зөвлөмж, холбогдох байгууллагын санал болон хавсралт хэсгээс бүрдэнэ.


**ТУСГАХ
МЭДЭЭЛЭЛ:**

Гүйцэтгэлийн аудитын тайлан аудитын асуудлын шинжилгээний 4 дэх түвшний асуулт бүрд хариулт өгч тэмдэглэгээ хийсэн ба 3 дахь түвшний асуултын хүрээнд ангилагдан бичигдсэн болно.

**ҮНДСЭН
МЭДЭЭЛЭЛ:**

Аймгийн ИТХ-ын 2022 оны 11 дугаар сарын 30-ны өдрийн 13 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар 24 их завсрын ажлыг 1,514.3 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан бөгөөд аймгийн ИТХ-ын 2023 оны 06 сарын 27-ны өдрийн 17 дугаар тогтоолоор 139.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж **1,654.1** сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр **1,543.6** сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 4 салбарын 24 барилга байгууламжийн их засварын ажлыг гүйцэтгэсэн байна.

Салбараар хэрэгжүүлсэн ТАХ-ний тоо, олгосон санхүүжилтийн дүнгээр харуулбал:/сая төгрөгөөр/

№	Салбар	ТАХ-ний тоо	мөнгөн дүн	Хувь
1	Боловсрол	12	864.30	56.0%
2	Эрүүл мэнд	6	240.10	15.6%
3	Соёл, урлаг	5	419.50	27.2%
4	Бусад	1	19.70	1.2%
Нийт дүн		24	1,543.60	100.0%

Эрдэнэбулган, Жаргалант, Хашаат сумдын ИТХ-аар 1,167.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 48 ТАХ-г хэрэгжүүлэхээр баталснаас 983.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгожээ. Тухайлбал:

Сумдын хөрөнгө оруулалтын хувьд:

№	Сумдын нэр	ТАХ-ний тоо	Баталсан төсөв	Гүйцэтгэл	
				тоо	Мөнгөн дүн
1	Хашаат сум	17	164.40	11	110.90
2	Эрдэнэбулган сум	26	946.50	23	846.90
3	Жаргалант сум	5	56.90	3	25.40
Нийт дүн		48	1167.8	37	983.2

Аймгийн авто замын сангийн хөрөнгө оруулалтын тухайд:

Аймгийн ИТХ-ын 2022 оны 11 дугаар сарын 30-ны өдрийн 13 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар авто замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 1,282.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 ТАХ-г 1,082.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан бөгөөд аймгийн ИТХ-ын 2023 оны 06 сарын 27-ны өдрийн 17 дугаар тогтоолоор 1,196.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 ТАХ-г 1,106.9 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр тодотгосон байна. Гүйцэтгэлээр 5 ТАХ-нд 1,058.8 сая төгрөгийн санхүүжилт олгож, 111.8 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлсэн байна.

Аймгийн ОНӨГ-т улс, орон нутгийн болон авто замын сангийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих 3,759.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2023 онд 3,669.5 сая төгрөгийг санхүүжүүлэх 24 ТАХ-ний тендер худалдан авалтыг зохион байгуулсан байна. / Эх сурвалж: ОНӨГ-ын 2024 оны 02 дугаар сарын 23-ны 19 дугаар албан бичиг/



АУДИТЫН ТАЙЛАН



2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР БАТАЛСАН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗУРАГ ТӨСӨВ, АЖЛЫН ДААЛГАВРЫГ ТӨСӨВ БАТАЛСНААС ХОЙШ БОЛОВСРУУЛСАН НЬ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬТАЙ НИЙЦЭХГҮЙ БАЙНА.

А1. Аймаг, сумын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан төсөл арга хэмжээ нь төлөвлөлтийн шаардлага хангаагүй, өмнөх зөрчил давтагдсаар байна.

Аймгийн ИТХ-ийн 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 17 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар 1,654.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 24 их засварын ажлыг гүйцэтгэхээр баталжээ. Харин Эрдэнэбулган, Хашаат, Жаргалант сумдын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1,170.3 сая төгрөгийн 47 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлахдаа анхны төсвөөс 101.5 сая төгрөгийг бууруулан баталсан байна.

Хүснэгт №1 Батлагдсан төсөл арга хэмжээний өөрчлөлтийг харуулбал

№	Төсөл арга хэмжээний нэр	Анх баталсан		Тодотгосон		Өөрчлөлт
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	
1	Аймаг	24	1,654.10	24	1,654.10	-
2	Эрдэнэбулган сум	21	1,048.00	26	946.50	101.5
3	Хашаат сум	16	166.90	16	166.90	-
4	Жаргалант сум	5	56.90	5	56.90	-
	Дүн	66	2,925.90	71	2,824.40	101.5

Эх сурвалж: аймаг, сумдын 2023 оны төсөв баталсан тогтоол

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төсөл арга хэмжээ нь эдийн засгийн тооцоолол, зураг төсөв, ажлын даалгаваргүй төсөл арга хэмжээг баталсан нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4¹ дэх заалттай нийцэхгүй байна.

Орон нутгийн авто замын сан

Аймгийн ИТХ-ын 2022 оны 11 сарын 30-ны өдрийн 13 дугаар тогтоолоор 2023 оны замын сангийн хөрөнгөөр 1,082.0 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 2023 оны 06 сарын 27-ны өдрийн 17 дугаар тогтоолоор 500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Цахир сумын төв доторх бетон хучилттай авто зам барих ажлыг Эрдэнэбулган сумын авто зогсоол зам засварын ажил болгон өөрчилсөн мөн 24.9 сая төгрөгөөр Цагаан давааны пост, хоёр модны рашааны дунд ослын зогсоолын талбай байгуулах ажлыг нэмэлтээр баталсан байна.

¹ 29.4.Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.



Хүснэгт №2 Батлагдсан төсөл арга хэмжээний өөрчлөлтийг харуулбал

№	Төсөл арга хэмжээний нэр	Анх баталсан	Тодотгосон	Өөрчлөлт
1	Цэцэрлэг хотын төв доторх хатуу хучилттай авто зам, хайрган, хучилттай авто замын засвар арчлалт	442.00	442.00	-
2	Чулуут сум Улаалзайн даваа Цохиотын давааны авто замын засвар	120.00	120.00	-
4	Эрдэнэбулган сумын 2 дугаар баг Арслан цохио чиглэлийн авто замын сувагчлалыг дуусгах	20.00	20.00	-
3	Цахир сумын төв доторх бетон хучилттай авто зам барих	500.00		500.00
4	Эрдэнэбулган сумын авто машины зогсоол, зам засвар тохижилт		500.00	(500.00)
5	Цагаан давааны пост, хоёр модны рашааны дунд ослын зогсоолын талбай байгуулах		24.9	(24.90)
	Дүн	1,082.00	1,106.9	(24.90)

Аймгийн автозамын сангийн хөрөнгөөр 2023 онд шинээр хэрэгжүүлэхээр баталсан төсөл арга хэмжээний 942.0 сая төгрөгийн 2 ТАХ-ний зураг төсөв, 164.9 сая төгрөгийн 3 ТАХ-ний ажлын даалгаврыг төсөв баталсны дараа боловсруулсан байна.

Аудитаас аймаг, сумын ОНТХО, автозамын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг батлахдаа Төсвийн тухай хуулийн 29.4 заалтыг мөрдөж ажиллах албан шаардлагыг аймаг болон Эрдэнэбулган, Жаргалант, Хашаат сумдын ИТХ-д хүргүүлээ.

A2. 2023 онд аймаг, сумдын орон нутагт төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний 15.5% нь урсгал шинжтэй арга хэмжээг санхүүжүүлэхээр баталсан байна.

Аймаг, сумдын орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2023 онд нийт 2,824.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 71 төсөл арга санхүүжүүлэхээр баталсан бөгөөд өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих төсөл арга хэмжээг төлөвлөж батлаагүй байна.

Хүснэгт №3 2023 онд төлөвлөсөн, хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний тоо, мөн дүн

№	Нэр	ИТХ-ар баталсан дүн		Хэрэгжүүлсэн арга хэмжээ		Төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээ	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	тоо	Мөнгөн дүн
1	Аймаг	24	1,654.1	24	1,543.6	-	-
2	Эрдэнэбулган сум	26	946.5	23	869.2	3	68.1
3	Хашаат сум	16	166.9	12	111.0	4	23.0
4	Жаргалант сум	5	56.8	1	6.0	4	50.9
	Дүн	71	2,824.3	60	2,529.8	11	142.0

Харин төсөл арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг үндэслэлтэй тооцоогүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй, хэрэгжих хугацаа, санхүүжих дүнг батлуулаагүй, урсгал шинжтэй арга хэмжээнд зарцуулахаар 142.0 сая төгрөгийн 11 төсөл, арга хэмжээг төлөвлөж батлуулжээ. Гүйцэтгэлээр эдгээр төсөл арга хэмжээг хэрэгжүүлээгүй байна. /Хавсралт-1/



Орон нутгийн авто замын сан

Аймгийн авто замын сангийн хөрөнгө оруулалтаар 2023 онд шинээр хэрэгжүүлэх 1,106.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 ТАХ-г Авто замын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3², 24.4³ дэх заалтын дагуу төлөвлөж баталсан байна.

Хүснэгт №4 Авто замын сангийн хөрөнгийн төлөвлөлт

№	Аймгийн ИТХ-ын тогтоол			Өмнөх оноос он дамжин хэрэгжих төсөл арга хэмжээ
	Төсөл арга хэмжээний	Тодотгосон 2023.06.27-ны 17 тогтоол	2023 онд санхүүжүүлэх дүн	
1	Цэцэрлэг хотын төв доторх хатуу хучилттай авто зам, хайрган хучилттай авто замын засварын арчлалт /замын нөхөөс/	442.0	442.0	
2	Чулуут сумын Улаалзайн даваа, Цохиотын давааны авто замын засвар	120.0	120.0	
3	Эрдэнэбулган сумын 2 дугаар баг Арслан цохио чиглэлийн авто замын сувагчлалыг дуусгах	70.0	20.0	48.1
4	Эрдэнэбулган сумын авто машины зогсоол, зам засвар, тохижилт /захын урьд зогсоол/	500.0	500.0	
5	Цагаан давааны пост, хоёр модны рашаан дунд ослын зогсолтын талбай байгуулах	64.9	24.9	16.7
Нийт дүн		1,196.9	1,106.9	64.8

Харин 48.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Эрдэнэбулган сумын 2 дугаар баг Арслан цохио чиглэлийн авто замын сувагчлалыг ажил, 16.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Цагаан давааны пост, хоёр модны рашаан дунд ослын зогсолтын талбай байгуулах ажлууд нь өмнөх оноос шилжин ирсэн бөгөөд 2022 онд тус ажлын төсөвт өртөг хүргэлцээгүйгээс он дамжин 2023 онд төсвийг нэмэгдүүлэн баталсан байна.

Төсөвлөлтийн шаардлага хангахгүй ТАХ-ийг төлөвлөж батлуулсан зөрчлийг таслан зогсоох, дараа онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т заасан шаардлагад нийцүүлэн боловсруулах арга хэмжээг авч ажиллах албан шаардлагыг аймаг, сумын Засаг дарга нарт хүргүүлээ.

А3. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн нийт төсөл арга хэмжээний 60 хувь буюу 36 төсөл арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэж олгоогүй байна.

Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2023 оны төлөвлөгөөнд их засварын 24 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж 1,654.1 сая төгрөг зарцуулахаар баталснаас, гүйцэтгэлээр 24 төсөл, арга хэмжээнд 1,543.6 сая төгрөгийн санхүүжилтийг гэрээнд заасны дагуу олгож, 63.1 сая төгрөгийг чанарын баталгаа болгож хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансанд, техник хяналтын зардлын 47.4 сая төгрөгийг аймгийн ерөнхий орлогын дансанд шилжүүлсэн байна.

Хүснэгт №4 Төсөл арга хэмжээний санхүүжилт олгосон байдал

² 24.3.Улсын авто замын сангийн хөрөнгөөр олон улс, улсын чанартай авто замын, нийслэл, орон нутгийн замын сангийн хөрөнгөөр нийслэл, орон нутгийн чанартай авто замын арчлалт, засварын ажлыг тус тус санхүүжүүлнэ.

³ 24.4.Авто замын сангийн хөрөнгөөр авто замын арчлалт, урсгал засвар, гэнэтийн хүчин зүйлээс хамаарсан засварын ажлыг тэргүүн ээлжинд санхүүжүүлнэ.



№	Нэр	ангилал										Нийт дүн	
		Барилга байгууламж		Их засвар		Тоног төхөөрөмж		Зам гүүр		Урсгал зардал		Тоо	Мөнгөн дүн
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн		
1	Аймаг			24	1,543.60							24	1,543.60
2	Эрдэнэбулган сум	2	158.00	7	193.00	6	147.80	7	310.4	1	60.00	23	869.20
3	Хашаат сум	1	5.90	2	22.60	5	73.30			4	9.20	12	111.00
4	Жаргалант сум									1	6.00	1	6.00
Дүн		3	163.90	33	1,759.20	11	221.10	7	310.40	6	75.20	60	2,529.80

Хүснэгтээс харахад нийт санхүүжилтийн 6.5 хувь нь барилга байгууламжийн, 69.5 хувь нь их засварын, 8.7 хувь нь тоног төхөөрөмж, 12.3 хувь нь зам гүүрний, 3.0 хувь нь урсгал шинжтэй зардалд тус тус зарцуулжээ.

Харин Эрдэнэбулган, Хашаат, Жаргалант сумын ОНТХО-аар хэрэгжүүлсэн 36 төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн санхүүжилтийг журмын дагуу хянан баталгаажуулаагүй, батлагдсан хяналтын хуудсыг хөтлөөгүй, ажил гүйцэтгэсэн эсэхийг нотлох анхан шатны баримтгүйгээр санхүүжилтийг олгосон байгаа нь Монгол Улсын засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт, тайлагнах журам-ын 2.3.2.4⁴, 2.3.2.5⁵, 4.10.1.1⁶ дэх заалттай нийцэхгүй байна. Иймд зөрчлийг таслан зогсоох давтан гаргахгүй байх албан шаардлагыг дээрх сумын Засаг дарга нарт хүргүүлээ.

Орон нутгийн авто замын сан

Орон нутгийн авто замын сангийн хөрөнгөөр 5 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр 1,106.9 сая төгрөгийг баталж, гүйцэтгэлээр 5 төсөл, арга хэмжээнд 946.8 сая төгрөгийг олгож, он дамжин хэрэгжиж байгаа 1 төсөл арга хэмжээний санхүүжилт 77.8 сая төгрөг мөн 2 төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн баталгааны 34.1 сая төгрөг нийт 111.8 сая төгрөгийг аймгийн Засаг даргын барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлсэн байна.

Хүснэгт №5 Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний санхүүжилт

№	Аймгийн ИТХ-ын тогтоол			Өмнөх оноос шилжиж ирсэн дүн	Гэрээ		Гүйцэтгэл		Барьцаа хөрөнгийн дансанд төвлөрсөн дүн
	Төсөл арга хэмжээний	Тодотгосон 2023.06.27 - ны 17 тогтоол	2023 онд санхүүжүүлэх дүн		Гүйцэтгэгч	Дүн	ЗСангийн данс	Барьцаа ХО-ын данс	
							Мөнгөн дүн	Мөнгөн дүн	

⁴ Төсөл, арга хэмжээний гэрээний удирдлагыг хэрэгжүүлэх, гүйцэтгэлийн санхүүжилтийг хянан баталгаажуулах, энэ журмын холбогдох хавсралтад заасан маягтын дагуу хяналтын хуудас хөтлөх”,

⁵ Төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эрхийг нээж, энэ журмын холбогдох хавсралтад заасан маягтын дагуу харьяа төрийн сангийн нэгжид хүргүүлэх

⁶ Захиалагч нь их засварын ажлын гүйцэтгэлийг ирүүлэхдээ гэрээгээр тохиролцсон их засварын ажлын календарчилсан төлөвлөгөө болон ажлын бодит гүйцэтгэлийг энэ журмын 8 болон 12 дугаар хавсралтад заасан маягтын дагуу мөнгөн дүнгээр илэрхийлсэн байдлаар гаргах бөгөөд их засварын ажлын зураг төсөв нь магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан байна



1	Цэцэрлэг хотын төв доторх хатуу хучилттай авто зам, хайрган хучилттай авто замын засварын арчлалт /замын нөхөөс/	442.0	442.0		ЛМДШ ХХК	442.0	412.9		29.1
2	Чулуут сумын Улаалзайн даваа, Цохиотын давааны авто замын засвар	120.0	120.0		Ноблоро уд ххк	120.0	68.7		5.0
3	Эрдэнэбулган сумын 2 дугаар баг Арслан цохио чиглэлийн авто замын сувагчлалыг дуусгах	70.0	20.0	48.1	Би кэй би констрак шн ххк	69.9	20.0	48.1	
4	Эрдэнэбулган сумын авто машины зогсоол, зам засвар, тохижилт /захын урьд зогсоол/	500.0	500.0		Саруулх аргуй ххк	498.1	420.4		77.8
5	Цагаан давааны пост, хоёр модны рашаан дунд ослын зогсолтын талбай байгуулах	64.9	24.9	16.7	Борхойн зам ХХК	64.9	24.8	16.7	
Нийт дүн		1,196.9	1,106.9	64.8		1,194.9	946.8	64.8	111.8

Харин өмнөх оноос шилжиж хэрэгжсэн 2 төсөл арга хэмжээний гүйцэтгэлд 64.8 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн данснаас олгосон байна.

**БҮЛЭГ Б.**

АЙМАГ, СУМДЫН ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ 87.5 ХУВИЙГ ГЭРЭЭНИЙ ХУГАЦААНД ГҮЙЦЭТГҮҮЛЖ АШИГЛАЛТАД ХҮЛЭЭН АВСАН БАЙНА

Б.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон авто замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн нийт ТАХ-ний хэмжээний 87.5 хувь нь гэрээний хугацаанд хэрэгжжээ.

Аймаг, сумдын ОНТХО, замын сангийн хөрөнгө оруулалтаар 2023 онд шинээр хэрэгжүүлсэн 3,584.1 сая төгрөгийн их засварын 64 төсөл арга хэмжээг гэрээний хугацаанд гүйцэтгэж, замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 498.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Эрдэнэбулган сумын авто машины зогсоол, зам засвар, тохижилт”-ын ажил нь он дамнан хэрэгжиж байна.

Хүснэгт №6 Он дамжин хэрэгжсэн төсөл арга хэмжээ

№	Сумын нэр	Гэрээний дүн		Он дамжин хэрэгжсэн төсөл арга хэмжээ	
		тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
1	Аймгийн ОНТХО	24	1,698.9		
2	Аймгийн замын сангийн хөрөнгө оруулалт	4	696.8	1	498.1
3	Эрдэнэбулган сум	23	1,071.4		
4	Хашаат сум	12	111.0		
5	Жаргалант сум	1	6.0		
Нийт дүн		64	3,584.1	1	498.1

Аймгийн ОНТХО-аар хэрэгжүүлсэн 263.6 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээний ажлын даалгаварт өөрчлөлт оруулжээ. Тухайлбал:

- Сайхан тэрх ХХК гүйцэтгэсэн 117.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Хайрхан сумын Соёлын төвийн их засварын ажлын даалгаварт өөрчлөлт оруулан гадна талын фасадын хөөсөн дулаалгын ажилд 6.0 сая төгрөгийг зарцуулсан.
- Сайхан тэрх ХХК гүйцэтгэсэн 48.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Ихтамир сумын ЕБС-ийн спорт заалны их засвар"-ын ажлыг гүйцэтгэхдээ ажлын даалгаварт өөрчлөлт оруулж гадна талын 2 төмөр хаалга, дотор талын 2 хавтастай хаалганы ажлыг хийж гүйцэтгэсэн.
- Аймгийн авто замын сангийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжсэн Эрдэнэбулган сумын 2 дугаар баг Арслан цохио чиглэлийн авто замын сувагчлалыг дуусгах ажлыг 68.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Би Кэй Би констракшн” ХХК гүйцэтгэсэн бөгөөд ажлын даалгаврын дагуу ажил гүйцэтгэх явцад төсөв хүрэлцээгүй зэргээс шалтгаалан гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан.
- Өндөр-Улаан сумын ЕБС-ын 29.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй завсрын ажлын даалгаврыг тайлант онд 2 удаа өөрчилсөн байна.



Б.2. Аймгийн авто замын сан, сумын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Аймаг, сумдын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжсэн 2.887.3 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 60 их засвар, 1,194.9 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 5 зам гүүрний барилга байгууламжийн ажлууд хэрэгжсэнээс авто замын сангийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 498.1 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээ нь он дамжин хэрэгжиж байна.

Аймгийн Засаг даргаас ГХБХБГ-тай байгуулсан 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний дагуу аймгийн ОНТХО-аар хэрэгжүүлсэн 24 ТАХ-ний ажлын гүйцэтгэлд захиалагчийн байнгын хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Харин Эрдэнэбулган, Жаргалант, Хашаат сумын ОНТХО-аар 1,078.3 сая төгрөгийн гэрээний дүнтэй ТАХ-нд захиалагчийн үе шатны хяналтыг мэргэжлийн байгууллагаар хэрэгжүүлээгүй нь Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.19 "Барилгын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, фото зургаар баримтжуулан, ил, далд ажлын актыг баталгаажуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Орон нутгийн авто замын сан

Авто замын сангийн хөрөнгө оруулалтаар 2023 онд гүйцэтгэсэн авто зам засвар арчлалтын 5 ажлын гүйцэтгэлд захиалагчаас үе шатны хяналтыг хэрэгжүүлээгүй нь Авто замын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6-д "Авто зам, замын байгууламжийн их засварын ажлын техник, технологийн хяналтыг тусгай зөвшөөрөл бүхий этгээдүүдээс сонгон шалгаруулж, гэрээ байгуулсны үндсэн дээр гүйцэтгүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитаас аймгийн авто замын сан, сумын ОНТХО-аар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэлд мэргэжлийн байгууллагаар байнгын болон явцын хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх арга хэмжээ авах албан шаардлагыг аймаг, сумдын Засаг дарга нарт хүргүүлээ.

Б.3. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн нийт ТАХ-нээс 446.5 сая төгрөгийн 9 төсөл арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.

Тайлант онд байнгын ашиглалтад хүлээн авсан 2,101.2 сая төгрөгийн 48 ТАХ-ээс 446.5 сая төгрөгийн их засварын 9 ТАХ-г ашиглагч байгууллага бүртгэл тайланд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4⁷, 14.4.2⁸, Монгол улсын Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн

⁷ 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ",

⁸ 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага",



хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 5.5.1⁹, 5.5.2¹⁰ дах заалттай нийцэхгүй байна.

Нягтлан бодох бүртгэлд тусгаагүй төсөл арга хэмжээ Хүснэгт-7

№	Төсөл арга хэмжээний нэр	Бүртэлд тусгах дүн	
		Тоо	Мөнгөн дүн
1	2,5-р багийн худгийн ухаалаг систем	1	20.0
2	Эрдэнэбулган сумын ЗДТГ, иргэний танхимын засвар, тохижилт, тоног төхөөрөмжийн зардал	1	68.4
3	4-р багийн иргэдэд үйлчлэх төвийн засвар	1	19.0
4	Цамхагт гэрэлтүүлэгийн засвар, үйлчилгээ	1	38.2
Эрдэнэбулган сумын ОНТХО-аар		4	145.6
1	Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн барилгын их засвар	1	82.50
2	Эрүүл мэндийн төвийн засвар	1	0.07
3	Ахуй үйлчилгээний барилгын засвар /үлдэгдэл санхүүжилт/	1	69.5
4	Соёлын төв, музейн барилгын засвар	1	19.9
5	Соёлын төвийн барилгын их засвар	1	128.9
Аймгийн ОНТХО-аар		5	300.9
Нийт дүн		9	446.5

Аудитаас улсын комиссын дүгнэлтээр байнгын ашиглалтад хүлээн авсан 446.5 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 9 ТАХ-г ашиглагч байгууллагын бүртгэлд тусгуулах албан шаардлагыг аймгийн ОНӨГ, Эрдэнэбулган сумын Засаг дарга нарт хүргүүлээ.

Б.4. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан байна.

2023 онд шинээр хэрэгжүүлсэн 65 төсөл арга хэмжээний ХАА-г зохион байгуулахдаа төсөвт өртөгт уялдуулан 47.7 хувь буюу 1,815.0 сая төгрөгийн 8 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг нээлттэй тендер шалгаруулалтаар, 42.1 хувь буюу 1,601.3 сая төгрөгийн 27 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулж, 10.1 хувь буюу 385.0 сая төгрөгийн 30 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчтэй шууд гэрээ байгуулсан байна.

№	ХАА-нд мөрдсөн журам, арга	ХАА-ны тоо	Орон нутгийн хөрөнгө оруулалт	Хувь
1	Нээлттэй тендер	8	1,815.0	47.7%
2	Шууд худалдан авах	30	385.0	10.1%
3	Харьцуулалт	27	1,601.3	42.1%
Нийт дүн		65	3,801.3	100%

⁹ 5.5.1-т "Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу төрийн болон орон нутгийн өмч байх буюу төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг байнгын ашиглалтад хүлээн авсан, тоног төхөөрөмж хүлээн авсан акт болон зураг төсөл, ТЭЗҮ-г захиалагч хүлээн авсны дараа төрийн болон орон нутгийн өмчид бүртгүүлнэ"

¹⁰ 5.2-д "Энэ журмын 5.5.1-д заасан хөрөнгийг төрийн болон орон нутгийн өмчид бүртгүүлэх чиг үүргийг захиалагчийн өмчийн асуудал хариуцсан нэгж (ажилтан) хэрэгжүүлэх бөгөөд өмчид бүртгүүлэхийг тодорхойлох урьдчилсан маягыг бөглөн цахим системээр гүйцэтгэлийн санхүүжилтийн хүсэлтэд хамт ирүүлж, цахим системийн өмчийн санд мэдээллийн санг бүрдүүлнэ"

**БҮЛЭГ В.****ХЭРЭГЖСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ 85.4 ХУВЬ НЬ ТӨЛӨВЛӨСӨН ҮР ДҮНД ХҮРСЭН БАЙНА.**

В1. Тайлант онд хэрэгжсэн нийт 60 ТАХ-г зориулалтын дагуу, бүрэн хүчин чадлаар ашиглаж байна.

Аймгийн хэмжээнд 2023 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 2,529.8 сая төгрөгийн 60 ТАХ-г зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар 100 хувь ашиглаж байна.

Хүснэгт-8 Ашиглалтад хүлээн авсан төсөл, арга хэмжээний судалгаа

ДД	Салбар	Ашиглалтад хүлээн авсан:		Бүрэн хүчин чадлаар ашиглахгүй байгаа		Бүрэн хүчин чадлаар ашиглаж байгаа		Хувь
		Төсөл арга хэмжээний тоо	Мөнгөн дүн	Төсөл арга хэмжээний тоо	Мөнгөн дүн	Төсөл арга хэмжээний тоо	Мөнгөн дүн	
1	Боловсрол	16	1,000.90	-	-	16	1,000.90	100%
2	Эрүүл мэнд	7	327.70	-	-	7	327.70	100%
3	Соёл урлаг	6	336.80	-	-	6	336.80	100%
4	Бусад салбар	31	864.40	-	-	31	864.40	100%
Нийт дүн		60	2,529.80	0	0	60	2,529.80	100%

В2. Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан ТАХ-ний 85.4 хувь нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн байна.

Аймгийн орон нутгийн 2023 оны төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 1,654.1 сая төгрөгийн 24 төсөл арга хэмжээний 85.4 хувь нь 2023 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй нийцсэн бөгөөд төлөвлөсөн үр дүнд хүрсэн байна.

В3. Өмнөх аудитаар өгсөн 2 заалт бүхий зөвлөмж, 6 албан шаардлагын хэрэгжилт дунджаар 75 хувьтай байна.

Холбогдох албан тушаалтан	Хүргүүлсэн зөвлөмж, Албан шаардлагын тоо	Хэрэгжээгүй	Бүрэн хэрэгжүүлсэн
Аймгийн Засаг дарга	1		1
Цэнхэр сумын засаг дарга	2		2
Жаргалант сумын засаг дарга	2	1	1
Хашаат сумын засаг дарга	2	1	
Цэцэрлэг сумын засаг дарга	1		1
Дундаж хувь			75%

Өмнөх аудитаар Цэнхэр, Жаргалант, Хашаат, Цэцэрлэг сумдын Засаг дарга нарт нийт 2 заалт бүхий зөвлөмж, 8 албан шаардлагыг хүргүүлж, биелэлтийг албан

бичгээр тооцож ирүүлснийг тулган шалгахад Жаргалант, Хашаат сумдад хүргүүлсэн 2 албан шаардлагыг хэрэгжүүлээгүй алдаа зөрчлийг давтан гаргасан байна.



Төсвийн төслийн өмнөх аудитаар хүргүүлсэн зөвлөмжийн биелэлтийн талаар

Орон нутгийн 2022 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитаас хүргүүлсэн зөвлөмжийн дагуу аймгийн Засаг даргаас 2023 онд төрийн өмчийн барилга байгууламжид судалгаа, хяналт шалгалт үзлэг хийх үүрэг даалгавар өгч, энэ хүрээнд аймгийн ГХБХБГ-ын даргын 2023 оны 09 сарын 11-ний өдрийн А/51

№	Салбар	их засвар	Урсгал засвар
1	Сургууль	12	7
2	Хүүхдийн цэцэрлэг	13	13
3	Эрүүл мэнд	11	3
4	Соёлын төв	4	5
5	Дотуур байр	11	1
6	Засаг даргын тамгын газар	6	2
Дүн		57	31

дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 19 сумын 173 барилга байгууламжид үзлэг шалгалт хийж дүгнэлт гарган барилга байгууламжийн ашиглалтын байдлыг үнэлж, их болон урсгал засвар хийх эрэмбэ дарааллыг тогтоосон байна. Аймгийн хэмжээнд их засвар хийх 57, урсгал засвар хийх 31 нийт 88 барилга байгууламжид нэгдсэн дүгнэлт гаргаж, суурь судалгааны сантай болжээ.

---oOo---



АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Аймаг, сумын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, авто замын сангийн хөрөнгөөр төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-ийг батлах зөрчил давтагдсаар байна.
- 2023 онд аймаг, сумдын орон нутагт төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний 15.5%-ийг урсгал шинжтэй арга хэмжээг санхүүжүүлэхээр баталсан байна.
- Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн нийт төсөл арга хэмжээний 60 хувь буюу 36 төсөл арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэж олгоогүй байна.
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон авто замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн нийт ТАХ-ний хэмжээний 87.5 хувь нь гэрээний хугацаанд хэрэгжсэн байна.
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэлд тавих хяналт сул байгаа нь их засварын ажил чанаргүй хэрэгжих нөхцөл бүрдсэн байна.
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 446.5 сая төгрөгийн 9 төсөл арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.
- Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан байна.
- Тайлант онд хэрэгжиж ашиглалтад хүлээн авсан нийт 60 ТАХ-г зориулалтын дагуу, бүрэн хүчин чадлаар нь ашиглаж байна.
- Аймаг сумдын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан ТАХ-ний 85.4 хувь нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн байна.
- Өмнөх аудитаар өгсөн 2 заалт бүхий зөвлөмж, 6 албан шаардлагын хэрэгжилт дунджаар 75 хувьтай байна.



АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ 85.4 ХУВЬТАЙ БАЙНА.

Аудитын дүн: Аудитаар нийт 2,586.2 сая төгрөгийн зөрчил илэрсэнд зөрчлийг таслан зогсоох 16 албан шаардлагыг аймгийн ИТХ, Засаг дарга болон холбогдох сумын засаг дарга нарт хүргүүллээ.

-----o0o-----



ХАВСРАЛТ №1

Төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээний жагсаалт

№	Төсөл арга хэмжээний нэр	Төсөл арга хэмжээ	
		тоо	мөнгөн дүн
1	Олон улс, ТББ -ын төсөл хөтөлбөрийн орон нутгийн оролцоо	1	36.1
2	4 багийн төвийн цэвэр бохир	1	17.0
3	4 дүгээр багийн өрхийн эмнэлгийг цэвэр бохир холбох	1	15.0
	Эрдэнэбулган сумын дүн	3	68.1
1	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зардал	1	2.0
2	Гамшгаас хамгаалах зардал	1	15.0
3	Ахамдын хорооны үйл ажиллагааны зардал	1	5.0
4	Хамтарсан багийн үйл ажиллагааны зардал	1	1.0
	Хашаат сумын дүн	4	23.0
1	Булгийн эх хамгаалах ажил	1	15.0
2	Голын усны хамгаалах бүс тогтоох, тэдгээрийг хаягжуулэх, тэмдэг тэмдэглээ хийх	1	20.0
3	Тарьц суулгац авах тарих	1	9.3
4	Гэрээт байгаль хамгаалагчийг цалинжуулах, урамшуулах	1	6.6
	Жаргалант сумын дүн	4	50.9
	Нийт дүн	11	142.0



ХАВСРАЛТ №2

Орон нутгийн 2023 оны төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн

төсөл арга хэмжээний жагсаалт

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	2023онд санхүүжих дүн	Гэрээний онгоо	Гүйцэтгэгч	Гэрээний дүн	Гүйцэтгэл
1	Аймгийн музейн барилгын засвар /Эрэнэбулган сум/	20.0	20.0	2023.04.05	Маргад Оюу буйлдинг ХХК	19.9	19.6
2	Бага сургууль, цэцэрлэгийн "Ирээдүй" цогцолбор сургуулийн барилгын их засвар /Эрэнэбулган сум/	50.0	50.0	2023.05.17	Сайхан тэрх ХХК	49.2	47.5
3	Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн барилгын их засвар /Эрэнэбулган сум/	100.0	100.0	2023.05.30	Уужим цамхаг ХХК	178.2	100.0
4	6 дугаар багийн Ерөнхий боловсролын сургуулийн спорт заалны барилгын халаалтын засвар /Эрэнэбулган сум/	50.0	50.0	2023.05.10	Сайхан тэрх ХХК	46.5	45.3
5	"Ар-Мөнхжин" өрхийн эрүүл мэндийн төвийн барилгын засвар /Эрдэнэбулган сум/ /Эрэнэбулган сум/	20.0	20.0	2023.10.13	Газрын гагнаас ХХК	20.0	19.6
6	Хүүхдийн 9 дүгээр цэцэрлэгийн барилгын засвар /Эрэнэбулган сум/	20.0	20.0	2023.05.29	Мандаачулуу ХХК	20.0	19.6
7	"Ар-Манал" өрхийн эрүүл мэндийн төвийн барилгын засвар /Эрдэнэбулган сум/	20.0	20.0	2023.12.08	Өлзийтээл ХХК	20.0	19.6
8	Ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль, хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн бохир усны шугам сүлжээний засвар, шинэчилэл /Эрэнэбулган сум/	240.0	240.0	2023.05.30	Толгод констракшн ХХК	236.1	205.7
9	Эрүүл мэндийн төвийн засвар /Цэцэрлэг сум/	64.1	64.1	2023.05.15	Цамхагт дел ХХК	63.7	62.0
10	Ахуй үйлчилгээний барилгын засвар /Цэцэрлэг сум	70.0	20.0	2023.02.03	Маргад Оюу буйлдинг ХХК	20.0	19.7
11	Соёлын төвийн барилгын их засвар /Хайрхан сум/	125.0	125.0	2023.05.23	Сайхан тэрх ХХК	117.7	108.3
12	Ерөнхий боловсролын сургуулийн барилгын их засвар /Хайрхан сум/	70.0	70.0	2023.05.03	Мөнхгэрэл мандах ххк	63.5	60.8
13	Сургуулийн их засвар /Хотонт сум/	40.0	40.0	2023.05.19	Маргад Оюу буйлдинг ХХК	38.3	37.6
14	Соёлын төв, музейн барилгын засвар /Ихтамир сум/	20.0	20.0	2023.05.10	Сайхан тэрх ХХК	19.9	19.5
15	Эрүүл мэндийн төвийн засвар /Ихтамир сум/	20.0	20.0	2023.05.29	Мандаачулуу ХХК	20.0	19.6
16	Ерөнхий боловсролын сургуулийн засвар /Ихтамир сум/	50.0	50.0	2023.05.18	Маргад Оюу буйлдинг ХХК	48.8	47.3
17	Ерөнхий боловсролын сургуулийн барилгын их засвар /Өлзийт сум/	120.0	120.0	2023.05.30	Тааффейт ХХК	118.1	110.4
18	Ерөнхий боловсролын сургуулийн спорт заалны барилгын их засвар /Өгийнүүр сум/	70.0	70.0	2023.05.19	Маргад Оюу буйлдинг ХХК	67.7	66.6
19	Соёлын төвийн барилгын их засвар /Төвшрүүлэх сум/	130.0	130.0	2023.10.02	Уужим цамхаг ХХК	128.8	126.3
20	Эрүүл мэндийн төвийн ариун цэврийн байгууламжийн ажлыг гүйцээх /Жаргалант сум/	55.0	55.0	2023.08.21	Ховд тул ХХК	54.9	54.9
21	Ерөнхий боловсролын сургуулийн барилгын их засвар /Цэнхэр сум/	100.0	100.0	2023.05.19	Сайхан тэрх ХХК	98.5	94.0
22	Эрүүл мэндийн төвийн уурын зуухны барилгын засвар /Чулуут сум/	70.0	70.0	2023.05.09	Бэлхи элч ХХК	69.6	64.5
23	Соёлын төвийн барилгын их засвар /Батцэнгэл сум/	150.0	150.0	2023.05.09	Энхтөгс тэмүүлэл ХХК	149.6	145.8
24	Сургуулийн засвар /Өндөр-Улаан сум/	30.0	30.0	2023.11.21	Эсгэл ХХК	29.9	29.4
25	Гэр хорооллын сайжруулсан болон шороон замын засвар, үерийн далан шуудууны засвар	138.0	138.0	2023.05.29	ЛМДШ ХХК	138.0	138.0
26	2,5-р багийн худгийн ухаалаг систем	20.0	20.0	2023.05.31	Э.Өлзийтогтох	20.0	20.0



27	Эрдэнэбулган сумын ЗДТГ, иргэний танхимын засвар, тохижилт, тоног төхөөрөмжийн зардал	70.0	70.0	2023.05.31	Маргад оюу бюлдинг ххк	69.7	68.4
28	Иргэдэд үйлчлэх нийтийн тээврийн үйлчилгээний хөнгөлөлт	60.0	60.0	2023.05.30	Нутаг хүнс трейд ххк	60.0	60.0
29	7-р багийн төв, өрхийн эмнэлэгийн засвар, өргөтгөл	90.0	90.0	2023.05.51	САСА ХХК	89.6	87.5
30	1-р багийн өрхийн эмнэлгийн арын голд гүүр барих	12.0	12.0	2023.10.27	С.Пүрэвсүрэн	12.0	12.0
31	Явган хүний далан нэмэлтээр барих	90.0	90.0	2023.06.15	Гурванхэц булаг ххк	90.0	87.6
32	Явган хүний зам тавих	10.0	10.0	2023.06.15	Гурванхэц булаг ххк	10.0	10.0
33	Хот тохижилт үйлчилгээний газарт автомашин	70.0	70.0	2023.05.30	ОТТО МИР ХХК	69.8	69.8
34	4-р багийн иргэдэд үйлчлэх төвийн завсар	19.0	19.0	2023.05.31	О.Нэргүйбаатар	19.0	19.0
35	2 модны рашааны ойролцоох автомашины зогсоол, тохижилт	20.0	20.0		Борхойн зам ххк	20.0	20.0
36	Цамхагт гэрэлтүүлэгийн засвар, үйлчилгээ	40.0	40.0	2023.03.13	Оджи од ххк	39.9	38.2
37	Ирээдүй цогцолбор сургууль, цэцэрлэгийн цахилгааны засвар	10.0	10.0	2023.05.31	иргэн н.Чингис	10.0	10.0
38	9-р цэцэрлэгийн цахилгааны засвар	10.0	10.0	2023.05.31	Тэргүүн ар ххк	10.0	10.0
39	4-р цэцэрлэгийн тоглоомын талбайн тохижилт	8.0	8.0	2023.12.08	Ургамалын далайн ххк	8.0	8.0
40	"Тэрбум мод" тарих хөтөлбөрийн хүрээнд Булган уулын зүүн талд мод тарьж, хайс хийх	20.0	20.0	2023.05.30	Төгс жавхланта жа са ба ххк	19.9	19.9
41	Сургууль цэцэрлэгийн засвар ТОСК байрны орц гарц хийх	33.0	33.0	2023.11.10	Өндөр дэнжийн булаг ххк	32.8	32.8
42	5-р багийн иргэдэд үйлчлэх төв худалдан авах /зөрүү/	120.5	70.5	202.11.27	Тайгер дизайн ххк	265.2	70.5
43	Тамир хорооллын ундны усны худгийг төвийн шугамд холбох	10.0	10.0	2023.09.15	ур ус ундарга ххк	10.0	10.0
44	Зүүн нарангийн зүүн талын булгыг хайс хийж мод тарих	20.0	20.0	2023.07.06	Ч.Гэлэг	19.5	19.5
45	3 дугаар цэцэрлэгийн сан техникийн засвар	20.0	20.0	2023.08.23	ИРГиргэн Н.Мягмар	20.0	20.0
46	Байрнуудын гадна талын тоглоом худалдан авах	33.0	33.0	2023.10.27	ДИ ТИ СИ БЭСТ МӨНХ ХХК	20.0	20.0
47	Нэгдсэн эмнэлэгийн арын зогсоол	17.0	17.0	2023.05.31	Цэнхэр давхар өлзий ххк	18.0	18.0
48	Радио	2.0	2.0	2023.07.07	Тамирын сүлжээ ххк	2.0	2.0
49	Бизнес хөгжлийн төв, задгай талбайн хашаажуулалт	3.7	3.7	2023.06.08	Төмөрт төгс хийц ххк	3.6	3.6
50	Хүнсний хангамж сайжруулах хүлэмж барих	6.0	6.0	2023.05.31	Алтын сапа ххк	6.0	6.0
51	Бог малын хээлтүүлэгчийн угаалга	1.5	1.5	2023.06.07		1.1	1.1
52	Мал эмнэлэгийн тасаг хөлдөөгч хөргүүр	1.5	1.5	2023.12.19	Аринакомпьютерс ххк	1.3	1.3
53	компьютер техник хэрэгсэл худалдан авах	15.0	15.0	2023.05.31	БСБ Компьютерс ххк	12.0	12.0
54	Мод тарих	10.0	10.0	2023.06.06	иргэд	2.6	2.6
55	Жаргалант Цагаанхад багийн засвар	1.5	4.0	2023.06.07	иргэд	3.8	3.8
56	ЗДТГ-ын байрны засвар	19.0	19.0	2023.06.06	иргэн Н.Баттулга	19.0	19.0
57	Мэдээллийн самбар	7.8	7.8	2023.08.03	Ньюгэрэлт ертөнц	6.0	6.0
58	Хогийн машин худалдан авах	53.9	53.9	2023.06.13	Солонгос улсаас авто машин нийлүүлэгчдийн холбоо ТТБ	51.8	51.8
59	Баяр наадмын зардал	19.5	19.5	2023.12.15	ЗДТГ	1.8	1.8
60	Шинээр баригдсан Соёлын төвд дроз авч өгөх	6.0	6.0	2023.03.10	Иргэн Цэнд-Аюуш	6.0	6.0
61	Цэцэрлэг хотын төв доторх хатуу хучилттай авто зам, хайрган хучилттай авто замын засварын арчлалт /замын нөхөөс/	442.0	442.0	2023.05.12	ЛМДШ ХХК	442.0	412.9
62	Чулуут сумын Улаалзайн даваа, Цохиотын давааны авто замын засвар	120.0	120.0	2023.05.31	Ноблероуд ххк	120.0	68.7



63	Эрдэнэбулган сумын 2 дугаар баг Арслан цохио чиглэлийн авто замын сувагчлалыг дуусгах	70.0	20.0	2022.09.08	Би кэй би констракшн ххк	69.9	68.1
64	Эрдэнэбулган сумын авто машины зогсоол, зам засвар, тохижилт /захын урьд зогсоол/	500.0	500.0	-	Саруулхаргуй ххк	498.1	420.4
65	Цагаан давааны пост, хоёр модны рашаан дунд ослын зогсолтын талбай байгуулах	64.9	24.9	2023.05.11	Борхойн зам ХХК	64.9	41.5
Нийт дүн		3,988.9	3,801.4	-	-	4,082.2	3,541.4



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ ТАЙЛБАР:

Шалгагдагч байгууллагаас тайлангийн төсөлтэй танилцаад саналгүй гэсэн хариу албан бичгийг ирүүлсэн.



АРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139
Утас/Факс: (976) 7033 3231,
Цахим шуудан: info@arkhangai.gov.mn,
Цахим хуудас: www.arkhangai.gov.mn

2024. 04. 18 № 03/578
танай _____-ны № _____-Т

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

“Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй холбоотой санал, тайлбаргүй болно.



ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ *Ш.Г.ГОМБОДОРЖ* Ш.ГОМБОДОРЖ

Наадамдорж С. Цог-Эрдэнэ
Машинд 2024.04.18

652400900788



ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



АРХАНГАЙ АЙМАГ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 16 өдөр

Дугаар 111

Эрдэнэбулган сум

Гүйцэтгэлийн аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.3 Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9, 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/102 дугаар тушаалаар баталсан "Эрх үүрэг шилжүүлэх тухай" тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1.1, 1.4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжийн дагуу "Улс, Орон нутгийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар, аймаг сумдын Засаг дарга болон ИТХ-ын даргад тус тус хүргүүлсүгэй.
4. Аудитын тайланд тусгагдсан зөвлөмж албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг гүйцэтгэлийн аудитын багийн ахлах аудитор (Г.Цог-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.БАЙГАЛМАА



Тэргүүлэх аудиторын 2024 онысарын
.....өдрийнтоот тушаалын хавсралт №2

"Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн аудитын зөрчлийн нэгтгэл

Аудитын код: АРА-2023/28-01-ШТА-ГА

№	Хүргүүлсэн шийдвэрийн			Хэрэгжилтийг хариуцах		
	Утга	Мөнгөн дүн	Тоо	Шийдвэр	Байгууллага, албан тушаал	Албан тушаалтны нэр
1	Архангай аймгийн ИТХ-ийн 2022 оны 11 дугаар сарын 30-ны өдрийн 13 дугаар тогтоолоор орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэхээр баталсан 1,654.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 24 төсөл арга хэмжээ, Эрдэнэбулган, Хашаат, Жаргалант сумдын ИТХ-аар баталсан 1,170.3 сая төгрөгийн 47 төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө эдийн засгийн тооцоолол зураг төсөв ажлын даалгаваргүй төсөл арга хэмжээг баталсан бөгөөд зураг төсөв, ажлын даалгаврыг 2023 онд боловсруулж баталсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т "Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана" гэсэн заалттай нийцэхгүй байна	-	4	Албан шаардлага	Аймаг, Эрдэнэбулган, Хашаат, Жаргалант сумдын ИТХ-ын дарга	Б.Батжаргал, Т.Ганзориг, Б.Гэрэлт-Од, Ц.Эрдэнэбулга
2	Аймгийн авто замын сангийн хөрөнгө оруулалтаар 2023 онд гүйцэтгэсэн 1,011.6 сая төгрөгийн 5-н авто зам засвар арчлалтын ажилд захиалагчаас үе шатны хяналтыг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь "Авто замын тухай хуулийн 22 зүйлийн 22.6-т "Авто зам, замын байгууламжийн их засварын ажлын техник, технологийн хяналтыг тусгай зөвшөөрөл бүхий этгээдүүдээ сонгон шалгаруулж, гэрээ байгуулсны үндсэн дээр гүйцэтгүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна	1,011.60	1	Албан шаардлага	Архангай аймгийн засаг дарга	Б.Цэрэннадмид
3	Эрдэнэбулган, Жаргалант, Хашаат сумдын ОНТХО-аар баталсан 142.0 сая төгрөгийн 11 төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө төсөвлөлтийг шаардлага хангаагүй төсөл арга хэмжээг баталсан байна Энэ нь Төсвийн тухай хуулийн 29.4 "Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана" гэсэн заалттай нийцэхгүй байна.	141.90	3	Албан шаардлага	Эрдэнэбулган, Жаргалант, Хашаат сумын Засаг дарга	Д.Мөнхбат, П.Алтанхуяг, Д.Дондов
4	Архангай аймгийн Хашаат, Эрдэнэбулган, Жаргалант сумдын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжүүлсэн 986.2 сая төгрөгийн 16 төсөл арга хэмжээнд захиалагчийн үе шатны болон байнгын хяналтыг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Монгол улсын Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт, тайлагнах журам"-ын 5.3.6-д "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг үнэн зөв гаргах, төсвийн хөрөнгийн зарцуулалт, барилгын чанарт тавих хяналтыг Төсвийн ерөнхийлөн захиргагч бүрэн хариуцна", 5.3.7-д "Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй барилга байгууламж, их засварын ажил бүрийг биечлэн хянаж, шалгах үүрэг бүхий захиалагчийн техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэгч этгээд нь хяналт хийсэн тухай бүр тэмдэглэл үйлдэж, гүйцэтгэл хавсрагч, их засварын ажил дууссаны дараа санхүүжилтийн баримт бичгийн хамт захиалагчийн архивад хадгалуулна" гэсэн заалттай нийцэхгүй байна.	986.20	3	Албан шаардлага	Эрдэнэбулган, Жаргалант, Хашаат сумын Засаг дарга	Д.Мөнхбат, П.Алтанхуяг, Д.Дондов
5	Тайлант онд байнгын ашиглалтад хүлээн авсан 2,101.2 сая төгрөгийн 48 ТАХ-нээс 446.5 сая төгрөгийн их засварын 9 ТАХ-г ашиглагч байгууллага бүртгэл тайланд тусгаагүй Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", Монгол улсын Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 5 дугаар зүйлийн 5.5.1-т "Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу төрийн болон орон нутгийн өмч байх буюу төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг байнгын ашиглалтад хүлээн авсан, тоног төхөөрөмж, хүлээн авсан акт болон зураг төсөл, ТЗЗУ-г захиалагч хүлээн авсны дараа төрийн болон орон нутгийн өмчид бүртгүүлнэ", 5.5.2-д "Энэ журмын 5.5.1-д заасан хөрөнгийг төрийн болон орон нутгийн өмчид бүртгүүлэх чиг үүргийг захиалагчийн өмчийн асуудал хариуцсан нэгж (ажилтан) хэрэгжүүлэх бөгөөд өмчид бүртгүүлэхийг тодорхойлох урьдчилсан маягтыг бөглөн цахим системээр гүйцэтгэлийн санхүүжилтийн хүсэлтэд хамт ирүүлж, цахим системийн өмчийн санд мэдээллийн санг бүрдүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.	446.50	2	Албан шаардлага	Аймгийн ОНӨГ-ын дарга, Эрдэнэбулган сумын ЗДарга	Х.Ганхуяг, Д.Мөнхбат
6	Сумдын орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 36 төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн санхүүжилтийг журмын дагуу хянан баталгаажуулаагүй, батлагдсан хяналтын хуудсыг хөтлөөгүй, ажил гүйцэтгэсэн эсхийг нотлох анхан шатны баримтуугээр санхүүжилтийг олгосон зөрчил илэрлээ Энэ нь Монгол Улсын засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт, тайлагнах журмын 2 зүйлийн 2.3.2.4-т "Төсөл, арга хэмжээний гэрээний удирдлагыг хэрэгжүүлэх, гүйцэтгэлийн санхүүжилтийг хянан баталгаажуулах, энэ журмын холбогдох хавсралтад заасан маягтын дагуу хяналтын хуудас хөтлөх", 2.3.2.5-т "Төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эрхийг нээж, энэ журмын холбогдох хавсралтад заасан маягтын дагуу харьяа төрийн сангийн нэгжид хүргүүлэх" 4.10.1.1-д "Захиалагч нь их засварын ажлын гүйцэтгэлийг ирүүлэхдээ гэрээгээр тохиролцсон их засварын ажлын календарьчилсан төлөвлөгөө болон ажлын бодит гүйцэтгэлийг энэ журмын 8 болон 12 дугаар хавсралтад заасан маягтын дагуу мөнгөн дүнгээр илэрхийлсэн байдлаар гаргах бөгөөд их засварын ажлын зураг төсөв нь магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан байна," гэж заасантай нийцэхгүй байна.		3	Албан шаардлага	Эрдэнэбулган, Жаргалант, Хашаат сумын Засаг дарга	Д.Мөнхбат, П.Алтанхуяг, Д.Дондов
Албан шаардлагын дүн		2,586.20	16			

